

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН СОНГОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ АЖИГЛАЛТЫН ТАЙЛАН



Улаанбаатар хот
2021 он

Талархал

Энэхүү сонгуулийн ажиглалтыг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (АНУОУХА)-ийн тусламжтайгаар Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн (БНОУХ)-гийн хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд Монголын багш эцэг эхийн холбооноос хийж гүйцэтгэв. Тайланд илэрхийлэгдсэн агуулга нь ажиглагчдын үзэл санаа бөгөөд АНУ-ын засгийн газар эсхүл дээрх агентлаг, хүрээлэнгийн албан ёсны байр суурь биш болно.

Мэдэгдэл

Тайлан дахь зургуудад дүрслэгдсэн хүмүүс БНОУХ-тэй хамааралгүй болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА

Товчилсон үгсийн тайлбар.....	4
НЭГ. Танилцуулга	5
ХОЁР. Бүрэлдэхүүн, сургалт бэлтгэл, арга зүй	6
ГУРАВ. Ажиглалтын үр дүн	11
ДӨРӨВ. Монгол Улс дахь анхны хөгжлийн бэрхшээлтэй сонгуулийн ажиглагчдын амжилт ба сургамж.....	25
ТАВ. ЗӨВЛӨМЖ	29
ЗУРГАА. ХАВСРАЛТ	30

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

АН	Ардчилсан нам
АНУОУХА	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
БНОУХ	Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МАН	Монгол ардын нам
МҮОНТ	Монголын үндэсний олон нийтийн телевиз
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХҮН	Хөдөлмөрийн үндэсний нам

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн ажиглалт

2009 онд Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн эрхийг баталгаажуулахдаа тэднийг бусад иргэн сонгогч, эсвэл нэр дэвшигчийн адил бүрэн дүүрэн оролцохыг нь баталгаажуулсан тохирох хуулийн арга хэмжээ авах, тэдний санал өгөх эрхийг хөгжлийн бэрхшээлээс нь болж хязгаарласан хуулийн заалтуудыг өөрчлөхийг НҮБ-ын Хүний эрхийн хорооноос зөвлөн, тус байгууллагын 2015 оны Монгол Улсын тайланд тусгасан байдаг.

Гэтэл сонгуулийн үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэд нэр дэвших болон сонгох эрхээ эдэлж чадахгүй байгаа нь өнөө цагт илэрхий ч тодорхой судалгаа баримт хангалтгүй, хуульд тусгасан ч амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлэх талаар иргэд, төрийн байгууллагуудад ойлголт муу байдаг нь илт юм. Иймээс АНУОУХА-гийн дэмжлэгтэйгээр БНОУХ-гийн хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд Монголын багш эцэг эхийн холбооноос “Хөгжлийн бэрхшээлтэй сонгогч иргэн” төслийг хэрэгжүүлэв. Ингэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн бүлгүүдтэй хамтран 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод хэр хүртээмжтэй буюу бие даан санал өгөх эрхийг хэр хангаж чадсан эсэхэд хараат бус хөндлөнгийн хяналт хийх ажлыг төлөвлөн гүйцэтгэв. Үүний тулд хөгжлийн бэрхшээлтэй сонгуулийн ажиглагчдыг СЕХ болон Бодлогод залуусын хяналт ТББ-тай хамтран бэлтгэж 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн мэдээлэл, орчны хүртээмжийг үнэлэх хараат бус, хөндлөнгийн ажиглагчаар бүртгүүлэв. Ингэснээр сонгуулийн мэдээллийн хүртээмж, санал авах өдөр сонгуулийн хэсгийн хорооны хүртээмжид хараа, сонсгол, хөдөлгөөний бэрхшээлтэй 16 ажиглагч, тэдний туслах, хөтөч, дохионы хэлний хэлмэрч болох 8 хүн нэмэгдэж нийт 24 хүн ажиллав.

Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн бие даан санал өгөх эрх хэрхэн хангагдаж буйг баримтжуулан олон нийтэд танилцуулах ажлыг биеллээ олоход тусалсан АНУ-ын иргэд, үр бүтээлтэй дэмжин хамтран ажилласан Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ)-ны Сонгогчийн боловсрол, сургалтын төв, Бодлогод залуусын хяналт ТББ болон БНОУХ-д талархаж байна.

Дараа дараагийн сонгуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрхийг хангахад ахиц дэвшил гарган, бүх нийтийн хүртээмжийг бүрдүүлэхэд дэмжлэг болгох зорилгоор ажиглалтын үр дүнгээс гадна холбогдох зөвлөмжүүдийг тайланд тусгасан болно.

Төслийн бусад үйл ажиллагаа

АНУОУХА-гийн дэмжлэгтэй, БНОУХ-гийн “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй сонгогч иргэн” төсөл нь сонгуулиар төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын боловсрол, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бусад олон төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдыг улс төрийн намын хөтөлбөр, бодлоготой танилцаж сонголтоо хийхэд нь туслах зорилгоор 2020 оны Улсын Их Хурал (УИХ), аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын (ИТХ) сонгуулиар болон 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар улс төрийн намуудтай уулзалт хийв.
2. Сонсголын бэрхшээлтэй сонгогчдын боловсролыг нэмэгдүүлж, мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилгоор монгол болон олон улсын дохионы хэл дээр сонгуулийн нэр томъёоны цахим толь бичгийг боловсруулав. Монгол дохионы хэлний 130, олон улсын дохионы хэлний 80 үгийн сантай толь бичгийг Сонгуулийн ерөнхий хорооны (СЕХ) www.gec.gov.mn цахим хуудаст байршуулж Монголын багш-эцэг эхийн холбооны www.ptamongolia.org цахим хуудаснаа хөтөч танилцуулгыг хийж олон нийтэд хүртээмжтэй болгов.
3. Сонгуулийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн хүртээмжтэй зохион байгуулах тухай сургалтыг 21 аймаг, 9 дүүргийн сонгуулийн хороо, хэсгийн 3500 гаруй ажилтанд зохион байгуулсан юм. Сургалтаар тэгш хамруулах зарчмыг тайлбарлаж, хөдөлгөөн, хараа, сонсголын бэрхшээлтэй сонгогчдод хүртээмжийг хэрхэн нэмэгдүүлэх, Ковид-19 цар тахлын үед хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн эрхийг хэрхэн хангах тухай зөвлөмжийг хүргэсэн.
4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар анх удаа олон улсын болон монгол дохионы хэлний хос синхрон орчуулгатайгаар СЕХ-ны сонгуулийн үйл явцын мэдээллийг хүргэж улс орон даяар төдийгүй олон улсад цацагдах тус сонгуулийн үйл явцыг сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэйгээр хүргэлээ.

ХОЁР. БҮРЭЛДЭХҮҮН, СУРГАЛТ БЭЛТГЭЛ, АРГА ЗҮЙ

Ажиглагчдын бүрэлдэхүүн

2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжилт сонгуулиар мэдээллийн болон сонгуулийн хэсгийн хорооны хүртээмжид хараа, сонсгол, хөдөлгөөний бэрхшээлтэй ажиглагч, тэдний туслах, хөтөч, дохионы хэлний хэлмэрчид ажиглалт хийв. Бүрэлдэхүүнд 16 хөгжлийн бэрхшээлтэй ажиглагч, 8 хөтөч, хувийн туслах, дохионы хэлний хэлмэрч бүхий нийт 24 хүн орж ажиллажээ.

Дээрх хөгжлийн бэрхшээлтэй ажиглагчдын бүрэлдэхүүнд 12 эмэгтэй, дөрвөн эрэгтэй ажиглагч байснаас

- харааны бэрхшээлтэй гурав,
- тулгуур эрхтний бэрхшээлтэй гурав,
- сонсголын бэрхшээлтэй 10 хүн байв.

Байршлын хувьд, хөгжлийн бэрхшээлтэй ажиглагчдын бүрэлдэхүүнд Дархан-Уул аймгаас сонсголын бэрхшээлтэй хоёр хүн, харин Завхан, Увс аймгуудаас харааны бэрхшээлтэй нэг нэг хүн оров.

Нийт 38 сонгуулийн хэсгийн хороонд ажиглагчаар бүртгүүлж Улаанбаатар хотын Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүрэг, Дархан-

Уул аймгийн Дархан хот, Завхан аймгийн Улиастай, Увс аймгийн Улаангомд санал авах байранд ажиглалт хийхэд дээрх 16 хөгжлийн бэрхшээлтэй ажиглагчаас 15 нь оролцсон ба үлдсэн нэг нь зөвхөн мэдээллийн хүртээмж дээр мониторинг хийв. Ажиглагчдын дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 1-ээс харна уу.

Сургалт, бэлтгэл ажил, арга зүй

Хөгжлийн бэрхшээлтэй ажиглагчдыг бэлтгэхэд хоёр өдрийн сургалтыг зохион байгуулав. Уг сургалтаар СЕХ-ны Сонгогчийн боловсрол, сургалтын төвийн дарга Б.Оюумаа сонгуулийн ажиглагчдын журам, ёс зүйн дүрэм, сонгуулийн хэсгийн хороодод зориулсан гарын авлагыг танилцуулсан бол олон жил сонгуулийн хараат бус хөндлөнгийн ажиглалт хийсэн туршлагатай Бодлогод залуусын хяналт ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүд Ц.Мандхайхатан, Т.Амарзаяа нар сонгуулиар хараат бус хөндлөнгийн хяналт хийх зарчим, туршлага, сургамж, ажиглагчийн ёс зүй, ажиглалтын шалгуурын талаар мэдлэг мэдээлэл өгөв.

Дээр дурдсан хоёр өдрийн сургалтын дараа оролцогчид сурснаа ярилцаж, төлөвлөгөө хэлэлцэх уулзалтуудад хамрагдав. Оролцогчид тус уулзалтуудаар дээр дурдсан чиглүүлэгчдийн тусламжтайгаар сонгуулийн ажиглалт хийх шалгууруудыг боловсруулав. Сургалтын оролцогчид а) сонсголын болон ярианы, б) харааны, в) хөдөлгөөний болон оюуны бэрхшээлтэй ажиглагчид гэсэн багуудад хуваагдав. Баг дотроо оролцогчид сонгох эрхээ хэрэгжүүлэхэд тулгарч байсан бэрхшээл болон амжилтын түүхээ мөн хуваалцаж туршлага солилцов.

Ажиглагч бэлтгэх үйл явцын дараах шатанд чиглүүлэгчид ажлын хэсгийн гишүүдийн туршлага хийгээд дээр дурдсан дотоодын болон олон улсын эх сурвалж, дүрэм журмуудын талаарх санал бодлыг сонсов. Цар тахлын үед халдвар хамгааллын дэглэмээс хамаарч сургалт, хэлэлцүүлгүүд онлайнаар дохионы хэлний синхрон орчуулгатай явагдсан болно. Сургалт болон хэлэлцүүлгийн үеэр ашигласан бүхий л сургалтын материал нь оролцогч нэг бүрийг сэдвээ бүрэн ойлгоход туслах зорилготой байв.

Үр дүнд нь ажлын хэсгээс ажиглалт хийхдээ дараах аргуудыг ашиглахаар тогтов:

1. Сонгуулийн өмнөх өдөр буюу 2021 оны 06-р сарын 08-нд санал авах байранд очиж хөгжлийн бэрхшээлтэй иргэн санал өгөхөд шаардлагатай тоног төхөөрөмж бий эсэхийг үнэлэх бөгөөд ингэхдээ санал авах байрны хүртээмж шалгах хуудсыг ашиглах (Хавсралт 2);
2. Сонгуулийн өмнөх өдөр санал авах байрны ажилчдын мэдлэг мэдээллийг үнэлэх ярилцлага;
3. Сонгуулийн өдөр санал авах байрны хүртээмжтэй байдал, ажилчдын хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй зохистой харилцаж буй эсэхийг үнэлэх ажиглалт;
4. Сонгуулийн сурталчилгааны үеэр телевиз, улс төрийн намуудын вэбсайт, кампанит ажилд ашиглагдсан материалуудад хэвлэлийн мониторинг хийж мэдээллийн хүртээмжтэй байдлыг үнэлэх зорилготой ажиглалт.

Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн сонгох, мэдээлэл авах, ажиглах эрхийн хэрэгжилтэд дараах таван дотоодын эрх зүйн баримт бичгийн хүрээнд шалгуур боловсруулан дүн шинжилгээ хийв (Эрх зүйн баримт бичгийн зүйл заалтын дэлгэрэнгүйг Хавсралт 3-аас). Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль

2. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (2020 он)
4. Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016 он)
5. Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөлийн 2009 оны 51 дүгээр тогтоол

Дээрх эрх зүйн баримт бичгүүдээс гадна, Монголын багш-эцэг эхийн холбооноос сонгуулийн ажиглалт хийх, асуулга авах арга зүйг боловсруулах явцад дараах гурван эх сурвалжийг ашигласан болно.

1. 2021 онд СЕХ-ноос шинэчлэн баталсан “Сонгууль ажиглах нийтлэг журам” ба “Сонгууль ажиглагчийн ёс зүйн дүрэм”

Энэхүү дүрэмд үндэслэн сонгуулийн нэг санал хураах байранд хоёр ажиглагчийг хуваарилав. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажиглалт хийх боломж олгохын тулд хувийн туслах, хөтөч эсвэл дохионы хэлний хэлмэрч хамтран баг бүрдүүлэн ажиллав. Харин мониторинг хийж гүйцэтгэх өдрүүдийг Сонгуулийн ажиглагчийн ёс дүрэмд үндэслэн тогтоов. Сонгуулиас өмнөх өдрүүдэд санал авах байруудын хүртээмжийг нягтлан үнэлсэн бол сонгуулийн өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэний сонгох эрх хэрхэн хангагдаж буйг ажиглан дүгнэх зорилготой байв. Мөн сонгуулийн өдөр сонгогчид болон санал авах байрны ажилчдаас санал асуулга авах нь зохисгүй тул сонгуулийн дараачийн өдөр санал авах байрны гадаа хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн судалгааг авсан болно.

2. Сонгуулийн хэсгийн хороодод зориулсан гарын авлага

Энэхүү гарын авлагад үндэслэн санал авах байрууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ширээ сандал, орох, гарах хаалга, саналын хуудас, бичвэр зааварчилгаа болон харилцах самбар зэргийг бэлдсэн эсэхийг шалгасан болно. Мөн түүнчлэн, санал авах байрны ажилчдад хөгжлийн бэрхшээлтэй сонгогчтой харилцах мэдлэг чадвар бий эсэхийг үнэлсэн болно.

3. Сонгуулийн тогтолцооны төлөө олон улсын сан (IFES)-гаас 2018 онд эрхлэн гаргасан Сонгуулиар хүртээмжийг ажиглах гарын авлага

Хөгжлийн бэрхшээлтэй ажиглагч бэлтгэх сургалтын үеэр ажлын багийнхны зохиосон сонгуулийн дараах асуулгын үндсэн агуулга болон арга зүйг энэхүү гарын авлагын дагуу засварлаж эцэслэсэн болно.

Мэдээллийн хүртээмж

Телевизийн мэдээллийн хүртээмж

Сонгуулийн сурталчилгааны хугацаанд буюу 2021 оны 05-р сарын 24-ний өдрөөс 06-р сарын 07-ны өдрийн хооронд, мөн санал авах өдрийн үйл явц, сонгуулийн үр дүнгийн талаарх мэдээлэл хүргэх өдөр болох 2021 оны 06-р сарын 09-10-ны өдрүүдэд мэдээллийн хүртээмжид хяналт тавихаар

- Монголын үндэсний олон нийтийн телевиз (МҮОНТ),
- ТВ9,
- Ийгл ТВ-ийг сонгон ажиглалт хийв.

Сонсголын бэрхшээлтэй 10, харааны бэрхшээлтэй 1, тулгуур эрхтний бэрхшээлтэй 3 ажиглагч ажиллав. Хөгжлийн бэрхшээлтэй ажиглагчид сонгосон телевизүүдээр гарсан сонгуультай холбоотой мэдээ мэдээллийг дараах байдлаар ажиглав. Үүнд:

1. Дохионы орчуулагчтай эсэх;
2. Дохионы орчуулагчийн дүрс нүдэнд харагдахаар хангалттай том байгаа эсэх;
3. Хадмал тайлбартай эсэх;
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар хүргэж байгаа эсэхийг ажиглав.

Нийгмийн сүлжээн дэх видео мэдээ

Ажиглагчид парламентад суудалтай, ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчтэй гурван улс төрийн нам болох

- Монгол ардын нам (МАН),
- Ардчилсан нам (АН),
- Зөв хүн электорат эвсэл - Хөдөлмөрийн үндэсний нам (ХҮН)-ын албан ёсны Фэйсбүүк хуудасны мэдээлэлд дээрх ажиглагчид сонгуулийн албан ёсны сурталчилгааны хугацаанд буюу 2021 оны 05-р сарын 24-ний өдрөөс 06-р сарын 07-ны өдрийн хооронд мониторинг хийв.

Ингэхдээ сонгуулийн сурталчилгааны нээлт, нэр дэвшигчийн хөрөг нэвтрүүлэг, үйл явдлын талаарх видео мэдээллийг дараах шалгуураар ажиглав:

1. Дохионы орчуулагчтай эсэх;
2. Дохионы орчуулагчийн дүрс зохистой хэмжээнд гарсан эсэх;
3. Хадмал тайлбартай эсэх.

Хэвлэмэл сурталчилгааны хүртээмж

Сонгуулийн албан ёсны сурталчилгааны өдрүүдээр хэвлэмэл сурталчилгааны хүртээмжийг ажиглахдаа харааны бэрхшээлтэй сонгогчдод зориулж брайль үсгээр хэвлэж түгээсэн эсэх, эсвэл сул хараатай иргэдэд зориулж том үсгээр хэвлэж түгээсэн эсэх гэсэн гол шалгуураар үнэлэв. Ингэхдээ орон нутаг даяар сонгогчдод хүрсэн сонгуулийн хэвлэмэл сурталчилгааны хүртээмжийг Увс аймгийн оршин суугч, ажиглагч үнэлэв.

Мэдээллийн хүртээмж дээр мониторинг хийхдээ ажиглагчид тэмдэглэл хөтөлж баримтжуулав (Хавсралт 4).

Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн саналаа өгөх эрхийн хэрэгжилт

Монголын багш-эцэг эхийн холбоо СЕХ-нд хөндлөнгийн ажиглагчаар ажиллахаар албан ёсоор бүртгүүлж баталгаажсанаар бэлтгэгдсэн ажиглагчдаас 15 хөгжлийн бэрхшээлтэй ажиглагч, 8 хөтөч, хувийн туслах, дохионы хэлний хэлмэрч бүхий нийт 23 хүн 38 сонгуулийн хэсгийн хороонд ажиглагчаар бүртгүүлж Ерөнхийлөгчийн сонгуулийн санал авах болон түүний өмнөх өдөр Улаанбаатар хотын Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргүүд, Дархан-Уул аймгийн Дархан хот, Завхан аймгийн Улиастай, Увс аймгийн Улаангом сумдад тус тус ажиллав.

Санал авах байрны хүртээмжийг дараах шалгуураар ажиглав (шалгуур хуудсыг Хавсралт 2-оос үзнэ үү). Үүнд:

- ✓ Санал авах байрны хүртээмж
- ✓ Санал авах байранд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид туслах үйлчилгээ
- ✓ Төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид тохируулах хэрэглэгдэхүүний хүртээмж
- Харааны бэрхшээлтэй сонгогч
- Хөдөлгөөний бэрхшээлтэй сонгогч
- Сонголын бэрхшээлтэй сонгогч
- Оюуны бэрхшээлтэй сонгогч

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрхээ хэрэгжүүлсэн туршлага

Сургалтад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгуульд ажиглалт хийхээс гадна саналаа өгсөн бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбогдож сонгууль, санал авах байр болон ажилчдынх нь хүртээмжтэй байдлын талаар өөрсдийн санаа оноогоо хуваалцаж энэхүү тайлангийн өмнө хэсэгт дурдагдсан сонгуулийн ажиглалтын үр дүнг дахин баталгаажуулж өгсөн юм. Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдоос 15 хөгжлийн бэрхшээлтэй ажиглагч орон даяар оршин сууж буй өөрсдийн хүрээлэл дэх хөгжлийн бэрхшээлтэй сонгогчидтой холбогдож, зөвхөн ажиглалтаар үр дүнг тодорхойлох боломжгүй нэмэлт асуултуудыг асуусан. Асуумжид санал авах байрны хүртээмжийн шалгах хуудаст багтаагүй санал авах байрны ажилчдын хандлага, санал өгөх үйл явц болон мэдээллийн хүртээмжийг тодруулах асуултуудыг багтаасан болно (Хавсралт 5). Зөвхөн ажиглалт хийгээд зогсохгүй хөгжлийн бэрхшээлтэй саналаа өгсөн иргэдийн бодит туршлагыг оролцуулснаар судалгааны үр дүнг гаргахад чухал үүрэг гүйцэтгэсэн болно.

Ажиглалт хийхдээ ажиглагчийн ёс зүйн дүрмийг чанад баримтлан хувь хүний нууцыг хамгаалж ажиллав.

Хөгжлийн бэрхшээлтэй сонгуулийн ажиглагчид мөн 59 хөгжлийн бэрхшээлтэй сонгогчоос санал хэрхэн өгсөн тухай асуумж авав. Оролцогчдын нас 19-50 настай, эдгээрээс 10% нь 25-аас доош насны залуу сонгогч байсан бол судалгаанд оролцогчдын 61% нь эмэгтэй байв.



График 1. Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн хүйс



График 2. Судалгаанд хамрагдсан иргэдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл

ГУРАВ. АЖИГЛАЛТЫН ҮР ДҮН

3.1 Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын мэдээлэл хүлээн авах эрхийн хэрэгжилт

3.1.1 Телевизийн мэдээллийн хүртээмж

- Нийт МҮОНТ, ТВ-9, Ийгл ТВ гэсэн гурван телевизийн сувгийн 2021 оны 05 дугаар сарын 24-наас 06 дугаар сарын 07-ны өдөр хүртэл улс төрийн намуудын бэлтгэсэн 14 нэвтрүүлгийг онцлон ажиглахад бүгд дохионы орчуулгатай байсан бол эдгээрээс 4 нэвтрүүлэг нь хадмал тайлбартай байсан.
- Улс төрийн намуудын сурталчилгаанууд ихэнхдээ хөгжлийн бэрхшээлтэй сонгогч иргэнд, ялангуяа сонсголгүй иргэдэд сурталчилгааг дохионы орчуулгатай хүргэж байгаа нь сайшаалтай байлаа.
- Зарим нэг тохиолдолд дохионы орчуулагчийн дүрс бүдэг, арын фон хэт бараан, хэлмэрчийн цонхны өмнүүр гарчиг, урсдаг зар явуулж таллаж харуулах зэрэг цаашид анхаарах зүйлс ажиглагдлаа.
- Сонгуулийн сурталчилгаанд огт хадмал тайлбар байхгүй, зарим нэг зурагт тайлбарт дохионы орчуулгагүй байсан. Нэг намын сурталчилгаанд 4 удаагийн хадмал тайлбар байсан хэдий ч зарим нэг үед зөвхөн зурагт тайлбарт байсан төдий.
- Сонгогчийн боловсрол олгох зорилготой СЕХ, иргэний нийгмийн байгууллагуудаас бэлтгэсэн видео сурталчилгаа бүр дохионы хэлний орчуулга, хадмал тайлбартай хүрч байв.
- Харин телевизүүд мэдээнээс бусад үед ерөнхийлөгчийн бүрэн эрх, сонгуулийн тогтолцоо зэргийн талаар сонгогчийн боловсрол олгох нэвтрүүлгээ дохионы хэлний орчуулга, хадмал тайлбаргүй хүргэсээр байв.
- СЕХ-ноос цаг үеийн мэдээллийг хүргэхдээ монгол болон олон улсын дохионы хэлний орчуулагч нартай хамт хүргэхэд зарим тохиолдолд зураглаачид хэлмэрчийг хасаж гаргах, эсвэл таллаж гаргах зэргээр хүртээмжгүй хүргэх тохиолдол гарч байлаа.

Давуу тал:

ТВ-ийн нэвтрүүлгүүдийг ажиглах хугацаанд нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, улс төрд хийж хэрэгжүүлсэн ажил, хувь хүн талаас нь гаргаж мэдээллээ дохионы хэлний орчуулгатай явуулж байсан тул сонсголгүй иргэдэд хүртээмжтэй байсан. Мөн ухрааж үзэх боломжтой телевизийн сувгуудаар гарч байсан нь цагт нь үзэж амжаагүй иргэд дараа нөхөж үзэх боломжтойгоороо давуу талтай байв.

Сул тал:



Нэвтрүүлэг гарч байгаа хугацаанд дохионы орчуулагчийн арын өнгө хэт бүдэг харанхуй, зарим тохиолдолд тал гарч, бас хэлмэрчийг үзүүлэх хэмжээ жижиг байсан. Өөрөөр хэлбэл стандартын дагуу хамгийн багадаа дэлгэцийн $\frac{1}{8}$ хэмжээнд үзүүлэх ёстой хэмжээнээс хэт жижиг байв. Дохионы хэл нь зөвхөн хуруугаар үсэглэн хүргэдэг хэрэглэгдэхүүн биш бие даасан “хэл” юм. Зөвхөн гар хуруугаар илэрхийлэгдэхгүй нүүр, амны хувирал хөдөлгөөн нь бүхэлдээ үг, ярианы утга агуулга, өнгө аясыг илэрхийлдэг тул ийнхүү зохистой түвшинд харуулахгүй байгаа

нь хүртээмжийг бууруулдаг. Мөн нэгэн жигд хэмжээгээр биш дугуй, дөрвөлжин гэх мэт өөр өөр дүрсээр гаргаж байгаа нь харахад зохимжгүй байсан.

Түүнчлэн, сурталчилгааны бүх хэсэгт хадмал тайлбар оруулсан бол мэдээллийн хүртээмжийг илүү сайн хангах байлаа. Зарим танилцуулга дээр дохионы орчуулагчийг гаргалгүй дүрс, бичвэр буюу зөвхөн яриа хэлбэрээр гаргаж байсан нь сонсголын бэрхшээлтэй иргэд мэдээллийг бүрэн авч чадахгүй өнгөрөхөд хүргэж байв.

Эдгээрийг МҮОНТ-ийн сувгаар гарсан нэврүүлгүүдээс жишээ татан үзүүлье.

Жишээ 1. Бичгээр мэдээлэл уншихдаа дохионы хэлмэрчийг гаргахгүй байв.

№	Тайлбар	Зураг
1.	МҮОНТ-ийн 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн мэдээний хөтөлбөр – Мэдээг унших үед дохионы хэлний орчуулагчийг гаргасан.	
2.	МҮОНТ-ийн 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн мэдээний хөтөлбөр – Нэр дэвшигчийн намтрыг унших үед дохионы хэлний орчуулагчийг гаргаагүй.	

Жишээ 2. Дохионы хэлмэрчийг зохисгүй харуулсан байдал

№	Тайлбар	Зураг
1.	2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн МҮОНТ-ээр АН-ын “Энэ миний түүх” нэвтрүүлгийн дохионы хэлмэрчийн арын фон хэт бараан бүүдгэр жижиг хэмжээнд үзүүлсэн.	

2.	2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн МҮОНТ-ээр ХҮН намын “Чүү” нэвтрүүлгээр дохионы хэлмэрчийг дөрвөлжин цонхоор зохимжгүй үзүүлсэн.	
3.	2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн МҮОНТ-ээр МАН-ын “Хөгжлийн хөтөлбөр” нэвтрүүлгээр дохионы хэлмэрчийн цонхыг хэт жижиг хэмжээтэй, хадмал тайлбаргүй үзүүлсэн байдал.	

3.1.2 Нийгмийн сүлжээний цахим хуудсан дахь видео мэдээ

- Намууд сонголгүй иргэдийн мэдээллийн хүртээмжийг анхаарч эрх үүргээ ухамсарлан телевизийн нэвтрүүлгээ дохионы хэлний хэлмэрчтэйгээр хийхээр хичээж байсан боловч нийгмийн сүлжээний видео мэдээлэлдээ дохионы хэлний хэлмэрчгүй эсвэл хэлмэрчийг хэт жижиг гаргаж, хүртээмжгүй хайхрамжгүй байдал гаргасан нь ажиглалт хийсэн сонголгүй иргэдийн тодорхойлсноор “дүр эсгэсэн” мэт харагдав.
- Цахим хуудсаар хадмалыг гаргахгүй байгаа нь нийгмийн сүлжээ, ялангуяа Фэйсбүүкийг түлхүү ашигладаг сонголгүй иргэдэд мэдээллээ хүртээмжгүй хүргэж буйн жишээ байлаа.
- Нийт гурван намын Фэйсбүүк хуудсаар 7 өдрийн турш дамжуулсан мэдээ, шууд хөтөлбөрийг ажиглахад зөвхөн 3 үйл ажиллагаа дохионы хэлний орчуулгатай байв.

Жишээ 3. Нийгмийн сүлжээний видео мэдээллийг хүргэсэн байдал

№	Тайлбар	Зураг
1.	ХҮН-ын нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаа эхэлсэн тухай 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хөтөлбөр дохионы хэлмэрчтэй байсан ч хэмжээ хэт жижиг, хадмал тайлбаргүй байв.	 <p>ЧҮҮ ХӨТӨЛБӨР (5-р сарын 30-ны дугаар)</p>

2.	ХҮН-ын нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны хаалтын 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдөр шууд дамжуулсан цахим уулзалт дохионы хэлмэрчтэй бөгөөд түүнийг тохиромжтой хэмжээнд үзүүлэв.	
3.	МАН-ын нэр дэвшигчийн Сэлэнгэ аймгийн сонгогчидтой хийсэн 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн уулзалтын шууд хөтөлбөр дохионы хэлний орчуулга болон хадмал тайлбаргүй байв.	
4.	МАН-ын нэр дэвшигчийн Төв аймгийн сонгогчидтой хийсэн 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн уулзалтын шууд хөтөлбөр дохионы хэлний орчуулга болон хадмал тайлбаргүй байв.	
5.	АН-ын нэр дэвшигчийн Чингэлтэй дүүргийн сонгогчидтой хийсэн 2021 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн уулзалтын шууд хөтөлбөр дохионы хэлний орчуулга болон хадмал тайлбаргүй байв.	
6.	АН-ын нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны хаалтын 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдөр шууд дамжуулсан уулзалт дохионы хэлмэрчтэй, хадмал тайлбартай байв.	

3.1.3 Хэвлэмэл сурталчилгааны хүртээмж

№	1	2	3
Хэвлэмэл бүтээгдэхүүн	2021.06.02	2021.06.03	2021.06.03

Хүлээн авсан огноо			
Хэвлэлийн нэр, товч агуулга	МАН-аас эрхлэн гаргасан ил захидал	МАН-аас эрхлэн гаргасан “Баялагтаа эзэн монгол” сонин	ХҮН-аас эрхлэн гаргасан “Монгол чадна” сонин
Бүтээгдэхүүний хэвлэлийн хэмжээ, хуудасны тоо өнгө, төрөл	A4, 1 хуудас, хар цагаан өнгөтэй	A3, 2 хуудас, 4 нүүр, өнгөт хэвлэл	A3, 2 хуудас, 4 нүүр, өнгөт хэвлэл
Брайль үсгээр хэвлэж хүргэсэн эсэх	Тийм	Үгүй	Үгүй
Сул хараатай хүнд зориулж том үсгээр хэвлэсэн эсэх	Тийм	Үгүй	Үгүй
Audio, DAISY форматад хөрвүүлж хүргэсэн эсэх	Үгүй	Үгүй	Үгүй
			

3.2. Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн саналаа өгөх эрхийн хэрэгжилт

3.2.1 Санал авах байрны орчны хүртээмж

Ихэнх санал авах байрыг улсын сургууль, цэцэрлэг, хороо, багийн байранд зохион байгуулдаг. Хүртээмжийг үнэлсэн 38 санал авах байрнаас 29 хувь нь буюу 11 байр нэгдүгээр давхарт байрладаггүй, хоёр, гуравдугаар давхарт эсвэл доод В1 давхарт байрлаж байсан ба ороход цахилгаан шат эсвэл тэргэнцэртэй иргэнийг зөөвөрлөх төхөөрөмж суурилуулаагүй, налуу замгүй байв.



Зураг 1. Баянзүрх дүүргийн 30 дугаар сургууль дээрх санал авах байр - 2 дугаар давхарт байрлах жишээ



Зураг 2. Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны байран дахь 30-5-1 дүгээр санал авах байр – доод давхарт байрлах жишээ

Санал авах байр луу орох болон гарахад 3-50 шатны гишгүүр давах шаардлагатай болсон. Үүнд, гадаа үүднээс барилга руу нэвтрэх, дотор ороод санал авах байр руу явах, санал авах байранд сургууль цэцэрлэгийн урлаг заалны тайзнаа байршуулсан санал тоолох төхөөрөмж рүү очих, санал авах байрнаас гарах хүртэл замын турш олон шат, өндөр босго давах нь хөл муу эсвэл тэргэнцэртэй сонгогчид хүртээмжгүй байв.



Зураг 3. Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургууль дахь 30-4-2 дугаар санал авах байр - налуу зам байхгүй жишээ



Зураг 4. Баянзүрх дүүргийн Шавь цогцолбор сургууль дахь санал авах байр – гарах хэсгийн дотор хаалга шаттай байгаа жишээ

Мөн санал авах байрнуудын 55 хувь нь налуу зам бүхий орцтой боловч эдгээрийн ихэнх нь MNS 6055:2009, MNS 6056:2009 стандартын дагуу өндөр уртын хэмжээ нь 1:12 харьцаа бүхий налуутай, халтирахааргүй гадаргуутай, тэргэнцэртэй иргэн чөлөөтэй зорчихоор өргөн замтай, бариул түшлэгтэй, эргэлт хийхээр чөлөөтэй тавцантай, хаалга нээж хаах хангалттай талбайтай байх шаардлагад нийцээгүй байна. Мөн хаалга нь тэргэнцэртэй хүн чөлөөтэй орох, гарах боломжгүй байв.



Зураг 5. Хан-Уул дүүргийн 29-13-1 дүгээр санал авах байр – гарах хаалганы налуу зам хэт өндөр, гулгамтгай гадаргуу, голдоо саадтай стандарт бус жишээ



Зураг 6. Баянзүрх дүүргийн 28-5-3 дугаар санал авах байр – гарах хэсэг хэт нарийн байгаа жишээ

Санал авах байрнуудын 85 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан ариун цэврийн өрөөгүй байв. Хаалганы өргөн 60 см, суултуур хаалганд тулсан тул тэргэнцэртэй орох боломжгүй, эсвэл шалыг өндөрлөсөн, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан бариулгүй гэх зэрэг асуудлууд түгээмэл байв.



Зураг 7. Сүхбаатар дүүрэгт байрлах МУИС-ийн Бизнесийн Сургууль дахь санал авах байрны ариун цэврийн өрөө – хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохиромжгүй байсан жишээ



Зураг 8. Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургууль дахь 30-4-2 дугаар санал авах байр – тэргэнцэртэй иргэн орох боломжгүй 60 см өргөнтэй хаалганы жишээ

Санал өгөхөөр очихдоо байрны гадаа болон дотор сууж хүлээх шаардлагатай сонгогчдод хүртээмжтэй сандал санал авах байрнуудын 60 хувьд байгаагүй.



Зураг 9. Сүхбаатар дүүргийн 69 дүгээр цэцэрлэг дээрх санал авах байр – хүлээлгийн сандалгүй жишээ



Зураг 10. Хан-Уул дүүргийн 29-13-1 дүгээр санал авах байр – хүлээлгийн сандалтай жишээ

Мөн санал авах гурван байр тутмын нэг нь дотроо тэргэнцэртэй иргэн чөлөөтэй зорчих орон зайг бий болгоогүй, эд зүйлсийг саад болохоор газарт байршуулан зохион байгуулсан байв. Тухайлбал, санал тоолох төхөөрөмжийг өндөрт байрлуулсан, эсвэл санал авах байраас гарахад шаттай нарийн хаалгаар гарахаар зохион байгуулжээ.



Зураг 11. Баянзүрх дүүргийн 32 дугаар цэцэрлэг дэх санал авах байр – санал тоолох төхөөрөмжийг өндөрт байрлуулсан жишээ



Зураг 12. Дархан-Уул аймгийн Дархан сумын 7-1-11 дүгээр санал авах байрнаас гарахдаа тайзаар дамжин гарч буй жишээ

Санал авах байрнуудын ихэнх нь гаднаа машины зогсоолтой боловч хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан замын тэмдэг бүхий зогсоол тусгайлан бэлдэж зохион байгуулаагүй байв. Мөн машины зогсоолын 33 хувь нь санал авах байрны орц болон гарцтай ойр байрлаагүй байв. Машины зогсоолоос санал авах байр луу ихэнх (63%) нь явган хүний замтай боловч талаас илүү хувь нь тэргэнцэртэй хүнд тохиромжгүй, саадтай байв.



Зураг 13. Баянзүрх дүүргийн Шавь цогцолбор сургууль дахь санал авах байр



Зураг 14. Баянзүрх дүүргийн Зэвсэгт хүчний 310 дугаар анги дахь санал авах байрны гадаа зогсоол – олон улсын стандартын дагуу бэлдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний авто машины зогсоолын хэсэггүй

Санал тэмдэглэх бүхээгийг нийт байрны 83 хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид зориулсан тэмдэглэгээ бүхий санал тэмдэглэх бүхээг бэлдсэн байсан ч тэдгээрийн 58 хувь нь тэргэнцэртэй иргэнд тохиромжгүй ширээ бэлтгэсэн байв. Тухайлбал, ширээний доор шүүгээтэй эсвэл тавцантай, хангалттай өргөн биш байв.



Зураг 15. Хан-Уул дүүргийн 29-12-1 дүгээр санал авах байр



Зураг 16. Сүхбаатар дүүргийн 71 дүгээр сургуулийн 3 дугаар давхарт байрлах санал авах байр

3.2.2 Санал авах байранд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид туслах үйлчилгээ

- Сонгуулиар хүртээмжийг нэмэгдүүлэхэд сонгуулийн хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллавал давуу талтай байдаг тухай сайн жишээ олон улсад байдаг. Монгол Улсын ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулиар сонгуулийн хэсгүүдэд нэг ч хөгжлийн бэрхшээлтэй ажилтан ажиллаагүй.
- Санал авах байрны ажилтнуудын 63 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийг дэмжих чиглэлээр сургалтад хамрагдсан гэж хариулжээ. Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчтой зохисгүй харилцсан тохиолдол гараагүй байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй сонгогч хүссэн тохиолдолд ажилтнууд

тусалж байсан байна. Гэвч сонсголгүй сонгогч ирэхэд харилцах самбар ашиглах тухай мэдэхгүй буюу ашиглахгүй, хараагүй сонгогчийг гараа ариутгахыг даалгасан боловч хаана байгааг чиглүүлэлгүй орхих, сул сонсголтой хүнтэй чанга хашхирч ярих, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүн бол өвчтөн учраас зөвхөн эмч хариуцна гэсэн ойлголттой байсан зэрэг жишээ байв.

- Ажиглалт хийх хугацаанд нийт 38 санал авах байранд 79 хөгжлийн бэрхшээлтэй эсвэл өндөр настан сонгогч туслалцаа авсан байна. Эдгээрээс 35 нь эмэгтэй сонгогч байв. Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын хувийн туслах, хөтөч буюу итгэмжилсэн төлөөлөгч нарын 50 хувь нь эмэгтэй байжээ.


	
<p>Зураг 17. Хан-Уул дүүргийн тэргэнцэртэй сонгогч хувийн туслахтай санал өгч байгаа жишээ</p>	<p>Зураг 18. Баянзүрх дүүргийн сонгогч санал тоолох төхөөрөмж дээр байрласнаас хувийн туслахтай гарч санал өгч байгаа жишээ</p>

3.2.3 Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид бие даан санал өгөх тохируулах хэрэглэгдэхүүн хангасан байдал

3.2.3.1 Харааны бэрхшээлтэй сонгогч

- Харааны бэрхшээлтэй сонгогчдод брайль хавтсыг сонгуулийн хэсэг бүрт хүртээмжтэй хуулийн дагуу хүргэсэн байна. Гэвч тус хавтсыг зөвхөн хэрэг болбол гаргаж ирнэ гэж далд байлгах, мөн үүнийг гарын хөдөлгөөнөө удирдахад бэрхшээлтэй сонгогчид хэрэглэх ёстой талаар мэдэхгүй, хараагүй сонгогчид өгөхдөө саналын хуудаст тааруулж өгөөгүй гэх зэргээр зохистой байдлаар хэрэглээгүй байна.
- Саналын бүхээгт аудио зааварчилгаа байгаагүй. Том үсгээр хэвлэсэн эсвэл хар дээр цагаанаар бичсэн санал тэмдэглэх зааварчилгаа зэргийг бэлтгээгүй байна. Хараагүй иргэд олноор суурьшдаг сонгуулийн хэсэг том үсгээр хэвлэсэн зааварчилгааг бүхээг дотор, ингэхдээ бүхээгийн дээд хаалтын улмаас уншигдахааргүй байрлуулсан байжээ. Гэвч бүхээгт томруулдаг шил, эсвэл томруулдаг дэлгэцийг ихэнх санал авах байранд байршуулсан нэгэн сайн жишээ байна. Зарим байранд ойрын харааны шилийг хүртэл нэмж байршуулжээ.

- Санал авах байрны гадна болон дотор хөтөч замыг нийт 38 санал авах байранд ажиглалт хийхэд зөвхөн 4 байранд л байрлуулжээ. Мөн санал авах байр дотроо тод чиглүүлэгч эсвэл ханын бариулыг байрлуулсан нь мөн л 4 санал авах байр байв.
- Саналын бүхээгт суухад гэрэлтүүлэг хангалттай сайн байсан байр 42.5 хувь байна. Гэрэлтүүлэг хангалтгүй газар нэмэлт гэрэлтүүлэг байрлуулаагүй байна.




Зураг 19. Сүхбаатар дүүргийн МУИС-ийн Бизнесийн Сургууль дээрх 28-7-1 дугаар санал авах байр – томруулагч шил, дэлгэц бэлтгэн зааврыг доторхой байрлуулсан сайн жишээ



Зураг 20. Хан-Уул дүүргийн 29-12-1 дүгээр санал авах байр – хараагүй иргэдэд зориулсан товгор замын сайн жишээ

3.2.3.2 Хөдөлгөөний бэрхшээлтэй сонгогч

- Саналын бүхээгийн ширээний тавцан өндөр, хангалттай зайтай бэлтгэсэн санал авах байр 55 хувь байлаа. Үлдсэн 45 хувь нь ширээ нь шургуулгатай, хөл тавих тавцантай, эсвэл хэт нарийн, намхан байгаагаас тэргэнцэртэй сонгогч бие даан саналаа тэмдэглэх боломжгүй заавал итгэмжилсэн төлөөлөгчөөр тэмдэглүүлэхэд хүргэсэн байна. Мөн хөлөө нугалж чадахгүй сонгогчид босоогоороо санал тэмдэглэх бүхээг нэг л санал авах байранд байсан ба бусад байранд байсангүй.
- Санал тоолох төхөөрөмжид саналын хуудсаа уншуулахад ихэнх байранд саадгүй байсан бол 7 байранд дээш тайз руу гарч өгөх шаардлагатай болсон байна. Өндөрт байрлуулсан тул саналын хуудсыг бусдын туслалцаатай өгсөн нь саналын нууцлал алдагдагдахад хүргэж байв.
- Гараа удирдахад бэрхшээлтэй сонгогчид зориулж том барьцтай үзэг байгаагүй, мөн брайль хавтсыг ашиглуулаагүй тул бусдын туслалцаатай саналаа тэмдэглэжээ.



Зураг 21. Хан-Уул дүүргийн 29-13-1 дүгээр санал авах байр – гарах хаалга саадтай жишээ



Зураг 22. Сүхбаатар дүүргийн 71 дүгээр сургуулийн 3 дугаар давхарт байрлах санал авах байр – ширээ орчим зай бага жишээ

3.2.3.3 Сонголын бэрхшээлтэй сонгогч


- Сонгуулийн хэсгийн ажилтнууд сонголгүй сонгогчийг ирэхэд дохионы хэлээр харилцаагүй байна. Дохионы хэл мэдэхгүй ч дохио зангаагаар юм уу цаас, харилцах самбар ашиглан харилцаж байсан 5 тохиолдол байжээ.
- Сонголын болон хэл ярианы бэрхшээлтэй сонгогчтой харилцах самбар ашиглахыг СЕХ-ноос гаргасан гарын авлагад заасан, загвар байдаг боловч ашигладаггүй, мэдэхгүй тохиолдол мөн дийлэнх санал өгөх байранд гарч байлаа.
- Сонголоо алдсан сонгогчтой чанга хашхирахгүйгээр бичгээр эвсэл амны хайрцгаар харилцаж байгаа сонгуулийн хэсгийн ажилтан 8 таарав.
- Санал авах байранд саналаа өгөхийн өмнө санал өгөх үйл явц болон санал тэмдэглэх зааварчилгааг өгсөн дохионы хэлний орчуулга, хадмал тайлбартай видеог орох хэсэгт үзүүлж байгаа 3 байр байжээ.



Зураг 23. Баянгол дүүргийн 24-3-1 дүгээр санал авах байр – явах чиглэлийг тодорхой үзүүлсэн жишээ



Зураг 24. Сонгинохайрхан дүүргийн 27-12-1 дүгээр санал авах байр – хамрах тойрог, явах чиглэлийг ойлгомжтой заасан жишээ



Зураг 25. Хан-Уул дүүргийн 29-12-1 дүгээр санал авах байр – хаалганы гадаа заавар хадсан сайн жишээ

3.2.3.4 Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сонгогч

- Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид зааврыг ойлгомжтой өгч байгаа 1 тохиолдол байлаа.
- Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид саналаа хэрхэн өгөхийг ойлгомжтой өгөх, тайван тусдаа сууж өгөх бололцоог бүрдүүлсэн байр цөөхөн байв.
- Бичиг үсгийн боловсрол багатай сонгогчид зориулан зургаар үзүүлсэн зааврыг мөн бүхээгт байрлуулаагүй байв. Харин саналын хуудаст нэр дэвшигчийн зурагтай байсан нь эдгээр сонгогчдод илүү хүртээмжтэй болгов.

3.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрхээ хэрэгжүүлсэн туршлага

Хөгжлийн бэрхшээлтэй сонгогч сонгуульд БИЕ ДААН ОРОЛЦОХ бололцоог бүрдүүлэх нь хамгийн чухал юм. Гэтэл асуумжийн үр дүнгээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд ихэвчлэн итгэмжилсэн төлөөлөгчийн туслалцаатай сонгуульд оролцдог, 90 хувь нь бие даан өгөх боломж хангагдаагүй байсныг онцолж байна.

Яагаад бие даан өгөх бололцоо бүрдээгүй талаарх нээлттэй асуултад дараах хариултаудыг өгсөн байна. Үүнд:

- Санал авах байр нь тохиромжгүй, гадна болон дотор олон шат, босготой;
- Сонгуулийн хэсгийн ажилтнууд өөрсөдтэй нь харилцаж чадаагүй;
- Мэдээллийг дохионы хэлний орчуулга, хадмал тайлбартай хүргээгүй;
- Санал тоолох төхөөрөмжийг өндөрт тавьсан буюу хүрэхэд саадтай байсан гэх мэт хариултаудыг түгээмэл өгчээ.

Харин яаж сонгуулийг хүртээмжтэй болгох вэ гэсэн асуултад дараах саналыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Сонгуулийн хэсгийн ажилтнуудад хөгжлийн бэрхшээлтэй сонгогчидтой хэрхэн харилцах болон санал авах байрыг хүртээмжтэй байгуулах талаар сургалт зохион байгуулах;
- Дэд бүтэц муутай хуучны байрны оронд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод хүртээмжтэй санал авах байр сонгож тохижуулах;
- Ерөнхийлөгчийн сонгуулиар саналын хуудас нэр дэвшигчийн зурагтай байгаа нь бичиг үсгийн боловсрол багатай, жижиг бичиг уншихад бэрхшээлтэй сонгогчдод хамгийн тохиромжтой байсан тул үүнийг бусад сонгуулиар ч хэрэгжүүлэх;
- Сонгуулийн хэсгийн ажилтнуудад шаардлагатай дохионы хэлний мэдлэгийг олгох эсвэл саналаа хэрхэн өгөх зааварчилгаа бүхий дохионы хэлээр бэлтгэсэн видео бичлэг тоглуулах гэх зэргээр сонголын бэрхшээлтэй сонгогчдод мэдээллийг хүртээмжтэй хүргэх арга замуудыг эрэлхийлэх гэсэн хариултаудыг түгээмэл өгсөн байна.

АСУУМЖИЙН ҮР ДҮН

Асуулт	Тийм	Үгүй
--------	------	------

Санал авах байранд таны хөгжлийн бэрхшээлийг ажиглаж, тусламж хэрэгтэй байгаа эсэхийг сонгуулийн хэсгийн ажилтан асуусан уу?	15	25%	44	75%
Санал авах байранд та өөрөө сонгуулийн хэсгийн ажилтнаас туслалцаа хүссэн үү?	13	22%	46	78%
Санал өгөхөд танд ялгаварлагдаж гадуурхагдсан юм шиг санагдсан уу?	9	15%	50	85%
Танд туслах үйлчилгээ үзүүлэх явцдаа таны саналаа бие дааж өгөх боломжийг хангасан уу?	45	76%	14	24%
Саналын хуудас танд ойлгомжтой байсан уу?	54	92%	5	8%
Саналаа тэмдэглэх хангалттай цаг хугацаа танд олгосон уу?	58	98%	1	2%
Нэр дэвшигчдийн талаар та хангалттай мэдээлэл авсан уу?	36	61%	23	39%
Саналын хуудас бөглөхөд хялбар байсан уу?	56	95%	3	5%
Саналын бүхээгийг ашиглахад танд саадгүй байсан уу?	53	90%	6	10%
Санал тоолох төхөөрөмжид саналын хуудсаа хийхэд саадгүй байсан уу?	54	92%	5	8%
Саналын хуудас дээр нэр дэвшигчийн зураг тод байсан уу?	57	97%	2	3%
Саналаа өгөхдөө та зураг, бичиг эсвэл дарааллыг харж тэмдэглэсэн үү?	44	75%	15	25%
Сонгуулийн хэсгээс танд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид сонгуулийг хэрхэн хүртээмжтэй зохион байгуулж буй талаар мэдээлэл өгсөн үү? Хэрвээ өгсөн бол танд ямар мэдээлэл өгсөн бэ?	35	59%	24	41%
Хэвлэл мэдээллээр танд мэдээлэл хангалттай хүргэсэн үү?	18	31%	41	69%
Танд туслах үйлчилгээ үзүүлэх явцдаа таны саналаа бие дааж өгөх боломжийг хангасан уу?	6	10%	53	90%

ДӨРӨВ. МОНГОЛ УЛС ДАХЬ АНХНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СОНГУУЛИЙН АЖИГЛАГЧДЫН АМЖИЛТ БА СУРГАМЖ

Төслөөр хараа, сонгол, хөдөлгөөний бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн төлөө ажилладаг 20 хүнийг сонгон сонгуулийн ажиглагчаар бэлтгэсэн билээ. Бүрэлдэхүүнд 15 эмэгтэй, 5 эрэгтэй ажиглагчдаас харааны бэрхшээлтэй 3, тулгуур эрхтний бэрхшээлтэй 4, сонголын бэрхшээлтэй 11, сонголын бэрхшээлтэй иргэдийн эрхийн төлөө ажилладаг 2 хүн ажиглагчаар бэлтгэгдэв. Эдгээрээс 4 ажиглагч Дархан-Уул, Завхан, Увс аймгийн хөгжлийн бэрхшээлтэй ажиглагч байсан.

Нийт ажиглагчид сонгуулийн сурталчилгааны хугацаанд, санал авах болон түүний дараах өдөр телевиз, цахим хуудас, сурталчилгааны хэвлэмэл бүтээгдэхүүний мэдээлэл хүртээмжтэй эсэхэд хяналт тавин ажилласан байна. Мөн ихэнх ажиглагчид сонсголгүй учраас телевиз, цахим хуудасны видео мэдээлэлд мониторинг хийсэн.

Бэлтгэгдсэн ажиглагчдаас 15 хөгжлийн бэрхшээлтэй ажиглагч, 9 хөтөч, хувийн туслах, дохионы хэлний хэлмэрч бүхий нийт 24 хүн 38 сонгуулийн хэсгийн хороонд ажиглагчаар бүртгүүлж Улаанбаатар хотын Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүрэг, Дархан-Уул аймгийн Дархан хот, Завхан аймгийн Улиастай, Увс аймгийн Улаангомд ажиглалт хийлээ. Бүгд анх удаа ажиглагчаар бэлтгэгдэн, анх удаа сонгуульд ажиглагчаар ажилласан.

Ажиглагчид 2021 оны 06 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд өөрийн бүртгүүлсэн сонгуулийн хэсэг дээр очиж ажиглан баримтжуулав. Хөгжлийн бэрхшээлтэй ажиглагчийн онцлогт нийцүүлэн явуулын ажиглалт хийхээр зохион байгуулсан бөгөөд нэг ажиглагч сонгуулийн өдөр 3 санал авах байранд нэг цагаас багагүй хугацаанд ажиглалт хийн тэмдэглэл хөтлөв.



Зураг 27. ХБИ-д зориулсан сонгуулийн ажиглалт хийх сургалтын үеийн зураг

Ажиглагчдын тайланд тусгасан сэтгэгдэл, амжилтын түүхээс:

- Сонгуулийн үйл явцыг бүхлээр нь таньж мэдэх боломжийг олгосон.

- Хүн бүрт хүртээмжтэй сонгуулийн тогтолцоог бий болгоход хувь нэмрээ оруулж байгаа нь сайхан байлаа.
- Анх удаа ажиглагчаар ажиллах сонирхолтой, эрх мэдэлтэй гэдгээ мэдсэн, сонгуульд оролцох талаар илүү мэдлэгтэй болж улс төрийг сонирхдог болсон.
- Бусдын адил эрх тэгш оролцож ажиглах боломжтой болж эхэллээ.
- Хэсгийн хорооны туршилтын үйл явц болон санал авах өдрийн үйл явцыг ажиглах эрх мэдэлтэй байгаад надад сайхан байв.
- Хэсгийн хорооны туршилтын үйл явцыг анх удаа харж ажиглалаа. Өмнө юу ч мэдэхгүй, тоодоггүй байсан.
- Сонсголгүй сонгогч иргэний санал өгөх үйл явцыг хөндлөнгөөс ажиглаж, хүртээмжийн тал дээр хэр байгааг олж харав.
- 2021.06.09-ны 07.00 цагт хэсгийн хороонд төрийн дуулал дуулсныг хараад сайхан байлаа.
- Сонгуулийн сурталчилгааны хугацаанд МҮОНТ, ТВ9, Ийгл гэсэн 3 телевизийн сувгаар улс төрийн нам, нэр дэвшигчийн мэдээллийн хүртээмжийн мониторинг хийж, дүгнэлт хэсэг дээр санал бодлоо чөлөөтэй бичиж цааш нь дамжуулсандаа баяртай байна.
- Нийгэмд анх удаагаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн улс төрийн сонгууль болон төрийн үйл ажиллагаанд оролцож ажиглаж болдог гэдгийг мэдэрсэн.
- ХБИ-дийнхээ хүртээмжийг сайжруулахад гар бие оролцож байгаадаа сэтгэл хангалуун байсан.
- Зарим хэсгийн хороо нь найрсаг хүлээж авч харилцан зөвлөлдөж, цаашдаа улам сайжруулах тал дээр харилцан ярилцаж байлаа.
- Сонгуулийн санал авах өглөө саналын хар машиныг байрлуулан, зөөврийн саналыг уншуулах үйл явцыг ажиглах, сонгуулийн ирц авах үйл ажиллагааг албан ёсоор нээж байгааг харах завшаан гарсан. Иргэнийхээ үүргийг нэр төртэй биелүүлж байгаадаа бахархалтай байв.
- Анх удаа ажиглалт хийх нь сонирхолтой байсан. Ажиглагчаар бүртгүүлэх, үнэмлэхээ авах үед сонгуулийн хэсгийн хороонд байсан ажилтнууд сонсголгүй хүн гэдгийг мэдэж, ажиглагчаар ажиллах гэж байгаад гайхаж харж байсан. Сонсголгүй хүн ч гэсэн ийм ажил хийж чадна гэдгийг харуулж, бардам байх сайхан байлаа.
- Ажиглалт, мониторинг хийх талаар хамтарч ажиллах хэсгийн хороодод танилцуулсны хүчинд тэд боломжоороо анхаарч ажиллах гэж хичээсэн нь бидний зохион байгуулж буй ажил зөв зүйл байжээ гэж бодогдсон. Томруулдаг шил хувь хүн айлаас хүртэл асууж сурагласан байсан. Хоёр хэсгийн хороо томруулдаг шил, брайль хавтас олж тавьсан байсан. Нэг хэсгийн хороо тэргэнцэр аваачиж тавьсан байсан.
- Ерөнхийлөгчийн сонгуулийн хэсгийн хорооны ажиглагчаар ажиллахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо маш чухал гэдгийг сонгуулийн хэсгийн хорооны бусад ажилчдад ойлгуулах нь хамгийн сайхан байсан.
- Хүмүүстэй санаа бодлоо солилцож, хоорондоо харилцаж, зааж зөвлөн бие биеэ дэмжиж энэхүү ажлын ард гарсандаа баяртай байна.
- Сонсголтой хүн нь сонсголгүй хүнтэй харилцах дохионы хэлний хэлмэрч ямар чухал болохыг ойлгож байв.
- Томруулдаг шилийг өндөр настнууд нь ашиглаж байгаа нь тааламжтай байв.

- Орчны хүртээмжийн хэмжилт үнэлгээг бодит байдал дээр дүн шинжилгээ хийхэд ялгаа харагдаад стандартын талаарх ойлголт мэдлэг маань дээшилсэнд баяртай байна.

Ажиглагчдад учирсан саад бэрхшээлээс:

- Дохионы хэлмэрчтэй хамт яваагүй тул хорооны хэсгийн ажилтнуудтай бичгээр харилцаж байлаа. Хэсгийн хорооны туршилтын үйл явцад дохионы хэлний хэлмэрчийн хүртээмжгүйгээс болж хангалттай мэдээлэл авч чадаагүй байна.
- Хэсгийн хорооны ажилтнуудын харилцаа хандлага муу байсан.
- Намайг сонсгожгүй гээд тэдний над руу харах өнцөг өөр байлаа. Миний бэрхшээлээс болж “ЧАДАХГҮЙ” гэсэн хандлагатай байна.
- 3 хэсгийн хорооны туршилтын үйл явцыг ажиглах цаг ижилхэн байсан тул зөвхөн 1 хэсгийн хороог л сонгож ажиглав.
- Хэсгийн хороодын дэд бүтцийн хүртээмжгүй байдал нэлээд хүндрэл учруулсан.
- Харааны бэрхшээлтэй намайг туслахаар бүртгүүлсэн хүнээ хамт авч орохыг ойлгож зөвшөөрөхгүй нэг байгууллагаас зөвхөн нэг хүн оруулна гэсэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ойлгоход зарим талаар хол байгааг харуулж байв. Ийм шаардлага тавьж байгаа учраас харахгүй зүйлээ утасны камераар томруулж харна гэж сонгуулийн хэсгийн хороодын дарга нарт хэлсэн боловч сонгуулийн өдөр хэсгийн хорооны зарим ажилтнууд утас хэрэглэхгүй байхыг ахин дахин анхааруулж байлаа. Сайн харахгүй байсан учраас бусад ажиглагчдад өөрийн ажиглах явцаа танилцуулсны дүнд тэд надад сайн тусалсан.
- Удаан хугацаагаар ажиглагч хийх явцад орчны хүртээмжгүй байдлаас болж бие засах гэх мэт өөрийн хэрэгцээг хангах тал дээр маш их бэрхшээлтэй байсан.
- Санал авах байрны агааржуулалтын систем муу учир их бүгчим, цар тахлын цаг үед эрсдэлтэй байсан.
- Нэг ажиглагч гурван хэсгийн хороонд 15 цагийн турш тасралтгүй ажиллахад хүндрэлтэй байсан. Цаашид хоёр ажиглагч хамтран ажиллавал хялбар санагдлаа.
- Хэсгийн хорооны ажилчид хангалттай мэдээллээр хангахгүй, асуултад дутуу хариулах, үл тоох шинжүүд ажиглагдлаа.
- Улс төрийн намуудын ажиглагчдад хаягтай ширээ бэлдсэн атлаа ТББ-ын ажиглагчид бэлдээгүй байсан нь улс төрөөс хараат бус ажиглалт хийж байгаа статусыг дордуулж байгаа мэт санагдсан тул аль болох зайтай суусан.
- Нэг байгууллагаас нэг хүнийг нэг л санал авах байранд бүртгэнэ гэсэн ойлголттой байсан тул гурван газар бүртгүүлнэ гэтэл хөдөө орон нутагт их гайхаж СЕХ-той холбож тайлбарлаж байж бүртгүүлсэн.
- Ажиглалт хийх үед өөрийн хүссэн мэдээллээ хангалттай авч чадаагүй. Зураг дарж болохгүй. Ийш тийшээ явахгүй гээд танхимын цаад булангийн телевиз дээрх гарч буй мэдээллийг авч чадахгүй хэцүү байлаа.
- Зарим тохиолдолд санал авах үед болж буй үйл явдлуудыг бүрэн ойлгож чадалгүй хоцрох тохиолдол гарсан. Хэдийгээр туслах ажилтантай хамт ажиглалт хийсэн боловч бүх процессыг нарийн тайлбарлуулах боломж хязгаарлагдмал байв. Үүнд ажиглалт хийх байрлал маш чухал нөлөө

үзүүлсэн. Тодруулбал, ажиглалт хийсэн нэг хэсгийн хорооны ажиглагчийн суудал нь яг сонгогч дайран өнгөрөх газартай давхцаж байсан учраас туслахтайгаа чөлөөтэй ярилцах, тэмдэглэл хийх зэрэг боломжууд хязгаарлагдмал болсон.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Сонгуулийг хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод хүртээмжтэй болгохтой холбоотой дараах зөвлөмжүүдийг боловсрууллаа.

Сонгуулийн ерөнхий хороонд

- Санал авах байрны дэд бүтцийн хүртээмжтэй байдлыг харгалзан сонгон зохион байгуулах, эсвэл түр хугацаагаар дэд бүтцийг хүртээмжтэй болгох зардлыг тусгаж хуваарилах.
- Дараа дараагийн УИХ, ИТХ-ын сонгуулиар саналын бүхээгт нэр дэвшигч нарын зураг бүхий хуудсыг бэлтгэн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн бүхээгт байршуулах.
- Сонгуулийн хороо, хэсгийн ажилтнуудад тэгш хүртээмжийн талаар сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй сургагч багшаар хүргэдэг байх.
- Сонгуулийн хэсэг, хороодод хөгжлийн бэрхшээлтэй ажилтан ажиллуулдаг болгох.
- Сонгогчийн боловсрол олгох мэдээллийн хүртээмжээ одоо хэрэгжүүлж байгаа дохионы хэлний орчуулга хадмал тайлбартай хүргэдэг сайн туршлагаа улам өргөжүүлэх, батжуулах.
- СЕХ-ноос хүргэж буй цаг үеийн мэдээллийг 2020, 2021 оны сонгуулиар сонсголтгүй хэлмэрчтэйгээр синхрон орчуулгатай хүргэж байгаа олон улсын стандартад нийцсэн тэргүүн туршлагаа үргэлжлүүлэх, батжуулах.

Улс төрийн намуудад

- Улс төрийн ухуулга, сурталчилгаанд үргэлж дохионы хэлний хэлмэрчтэй хамт мэдээлэл хүргэх.
- Видео мэдээллээ байнга дохионы хэлний орчуулга, хадмал тайлбартай хүргэж байх.
- Хэвлэмэл сурталчилгаагаа харааны бэрхшээлтэй сонгогчдод хүртээмжтэйгээр брайль, том үсгээр, хар дээр цагаанаар гэх мэтчилэн тохиромжтой хэвлэн сонгогчдоо судлан тохирох сурталчилгааг хүргэж байх.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах тухай намын дүрэмдээ тодорхой тусган улс төрийн намын ажилтнууд болон нэр дэвшигчдийн дунд квот тогтоон оруулж байх.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудад

- Телевизийн болон цахим хуудсаар сонгогчийн боловсрол олгох төлбөргүй видео мэдээлэл хүргэхдээ аудио тайлбартай, дохионы хэлмэрчтэй хүргэж байх.
- СЕХ-ноос дохионы хэлний орчуулагчтай мэдээллээ хүргэж байхад орчуулагчийг хасах, эсвэл хагаслан харуулахгүйгээр бүрэн гүйцэт дүрсэд оруулж, хүний эрхийн мэдрэмжтэй хүргэх, зураглаачийг бэлтгэн сургах.
- Телевизийн мэдээ, хөтөлбөрт хэлмэрчийг дэлгэцийн наймны нэгээс багагүй талбайд цоолж үзүүлж байх. Ингэхдээ өмнүүр нь гарчиг, дүрс лого дарж хааж харуулахгүйгээр үзүүлж байх.

ЗУРГАА. ХАВСРАЛТ

Хавсралт 1. Ажиглагчдын мэдээлэл

№	Овог нэр	Хүйс	Хөгжлийн бэрхшээлийн төрөл, туслахын үүрэг	Ажиглалт хийсэн байршил
1	Бумчин Бямбасүрэн	Эм	Сонсголын бэрхшээлтэй	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 16,17,18 дугаар хороо
2	Цэндсүрэн Амарзаяа	Эм	Сонсголын бэрхшээлтэй	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо
3	Нацагдорж Дэлгэрмаа	Эм	Дохионы хэлмэрч	Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 4, 5, 7 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо
4	Болдоо Анужин	Эм	Сонсголын бэрхшээлтэй	Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 4, 5, 7 дугаар хороо,
5	Пүрэвжаргал Отгонжаргал	Эм	Сонсголын бэрхшээлтэй	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 7, 8, 11 дугаар хороо
6	Батнасан Нэмэхбаяр	Эр	Сонсголын бэрхшээлтэй	Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо
7	Буриад Хулан	Эм	Сонсголын бэрхшээлтэй	Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, Баянгол дүүргийн 18 дугаар хороо
8	Магсар Ганбаатар	Эр	Сонсголын бэрхшээлтэй	Зөвхөн мэдээллийн хүртээмж
9	Ичинноров Болормаа	Эм	Дохионы хэлмэрч	Дээрх сонсголгүй ажиглагчдад хуваариар ажиллах
10	Сэр-од Бямбадэлгэр	Эм	Дохионы хэлмэрч	Дээрх сонсголгүй ажиглагчдад хуваариар ажиллах
11	Буянхишиг Юмжирдулам	Эм	Сонсголын бэрхшээлтэй	Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, 16 дугаар хороо
12	Батсүрэн Туул	Эм	Сонсголын бэрхшээлтэй	Дархан-Уул аймаг, Дархан хот
13	Жамсран Батбаяр	Эр	Сонсголын бэрхшээлтэй	Дархан-Уул аймаг, Дархан хот
14	Хуяг-Очир Сэлэнгэ	Эм	Дохионы хэлмэрч	Дархан-Уул аймаг, Дархан хот
15	Зоригт Ширнэн	Эр	Харааны бэрхшээл	Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Баянгол дүүргийн 3 дугаар хороо, Сонгино-хайрхан дүүргийн 12 дугаар хороо

16	Лхагвасүрэн Цэрэннадмид	Эм	Хөтөч	Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Баянгол дүүргийн 3 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 12 дугаар хороо
17	Батдэлэг Отгонжаргал	Эм	Харааны бэрхшээл	Увс аймаг, Улаангом сум
18	Гүсэнжав Должинсүрэн	Эм	Харааны бэрхшээл	Завхан аймаг, Улиастай сум
19	Должинс үрэн Очир Эрдэнэ	Эр	Хөтөч	Завхан аймаг, Улиастай сум
20	Хишигт Батчимэг	Эм	Тулгуур эрхтний бэрхшээл	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо, 5 дугаар хороо
21	Ухнаа Гансүх	Эр	Хувийн туслах	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо, 5 дугаар хороо
22	Сэнгээбаатар Одончимэг	Эм	Тулгуур эрхтний бэрхшээл	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 8 дугаар хороо
23	Батжаргал Энхням	Эм	Тулгуур эрхтний бэрхшээл	Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо
24	Болдбаатар Удаанжаргал	Эм	Хувийн туслах	Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо, Цэргийн анги

Хавсралт 2. Санал авах байр, санал өгөх үйл явцын хүртээмжийг шалгах хуудас

Санал авах байрны хүртээмжийн мониторинг			
Ажилагчийн овог нэр:			
Хүйс:			
Ажиглагчийн хөгжлийн бэрхшээлийн төрөл:			
Огноо:			
Аймаг дүүрэг:			
Сонгууль:		Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль 2021	
Сонгуулийн хэсгийн байршил:			
Санал авах байрны дугаар:			
Санал авах байрны хүртээмж			
№	Асуулт	Хариулт	
1.	Санал авах байр нэгдүгээр давхарт байрласан уу?	Тийм	Үгүй
1а.	Хоёроос дээш давхарт бол цахилгаан шаттай байна уу?	Тийм	Үгүй
2.	Санал авах байр луу орох, гарах шатны гишгүүр хэд байна вэ?	Байхгүй	Тоо:
2а.	Хэрвээ шаттай орц, гарцтай бол налуу зам байна уу?	Тийм	Үгүй
2б.	Налуу зам, хаалганы өргөн, босго нь стандартад нийцсэн байна уу? Тэмдэглэгээ:	Тийм	Үгүй
3.	Санал авах байранд дараах зүйлс байна уу:		
	Ариун цэврийн өрөө нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохиромжтой байна уу?	Тийм	Үгүй
	Сууж хүлээх шаардлагатай хүн бүрт хүртээмжтэй сандал байна уу?	Тийм	Үгүй
	Тэргэнцэртэй хүн чөлөөтэй хөдлөх зайтай байна уу?	Тийм	Үгүй
	Танхимын шал болон дээр эд зүйлс нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд саад учруулахааргүй байна уу?	Тийм	Үгүй
	Саналын бүхээгтэй хэсэг саадгүй байна уу?	Тийм	Үгүй
4.	Орох, гарахад өргөн хаалгатай байна уу?	Тийм	Үгүй
	Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид зориулсан машины зогсоол бэлдсэн байна уу?	Тийм	Үгүй

5.	Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид зориулсан машины зогсоол санал авах байрны орц, гарцтай ойр байна уу?	Тийм	Үгүй
6.	Машин зогсоолоос санал авах байр руу ороход явган хүний зам байна уу?	Тийм	Үгүй
7.	Санал авах байр руу явах зам нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй байна уу?	Тийм	Үгүй
8.	Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид саналын бүхээг бэлдсэн байна уу?	Тийм	Үгүй
8а.	Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид зориулсан бүхээг нь тэргэнцэртэй иргэнд тохиромжтой байна уу?	Тийм	Үгүй
Санал авах байранд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид туслах үйлчилгээ			
9.	Сонгуулийн хэсэгт ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй ажилтан байна уу? Байгаа бол ямар хөгжлийн бэрхшээлтэй болохыг тэмдэглэнэ үү:	Тийм	Үгүй
10.	Санал авах байрны ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийг дэмжих чиглэлээр сургалтад хамрагдсан уу? (санал авах байрны ажилтнаас асуух)	Тийм	Үгүй
11.	Санал өгөхөд хөгжлийн бэрхшээлтэй сонгогч өөрөө хүссэн тохиолдолд туслалцаа үзүүлж байсан уу? <i>Үгүй бол тайлбарлана уу:</i>	Тийм	Үгүй
12.	Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид туслах, итгэмжилсэн төлөөлөгч, эсвэл сонгуулийн хэсгийн ажилтан зохисгүй харьцсан уу? <i>Хэрвээ тийм бол асуудлуудыг бичнэ үү:</i> 1. 2.	Тийм	Үгүй
13.	Ажиглалт хийх хугацаанд нийт хэдэн сонгогч туслалцаа авсан бэ? Үүнээс хэд нь эмэгтэй байсан бэ?	Нийт:	Эмэгтэй:

14.	<p>А. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй сонгогчийн хэд нь эмэгтэй итгэмжилсэн төлөөлөгчтэй байсан бэ?</p> <p>В. Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй сонгогчийн хэд нь эмэгтэй итгэмжилсэн төлөөлөгчтэй байсан бэ?</p>	А:	В:
Төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид тохируулах хэрэглэгдэхүүний хүртээмж			
Харааны бэрхшээлтэй сонгогч			
15.	Харааны бэрхшээлтэй сонгогчид зориулсан брайль үсгээр хэвлэсэн эсвэл аудио заавар байна уу?	Тийм	Үгүй
16.	Санал тэмдэглэл хийхийг том үсгээр мөн хар дээр цагаанаар хэвлэсэн заавар байна уу?	Тийм	Үгүй
17.	Томруулдаг шил эсвэл томруулдаг дэлгэц байршуулсан байна уу?	Тийм	Үгүй
18.	Санал авах байрны гадна болон дотор хөтөч зам байна уу?	Тийм	Үгүй
18 а.	Санал авах байранд тод чиглүүлэгч, ханын бариул байна уу?	Тийм	Үгүй
19.	Санал авах бүхээгт гэрэлтүүлэг хангалттай байна уу, эсвэл нэмэлт гэрэлтүүлэг байршуулсан байна уу?	Тийм	Үгүй
Хөдөлгөөний бэрхшээлтэй сонгогч			
20.	Санал тэмдэглэх ширээний тавцангийн өндөр тохиромжтой байна уу?	Тийм	Үгүй
21.	Санал тэмдэглэх бүхээгийг ашиглахад хангалттай зай байна уу?	Тийм	Үгүй
22.	Санал тоолох хайрцагт саналын хуудсаа хийхэд тохиромжтой байна уу?	Тийм	Үгүй
23.	Гараа удирдахад бэрхшээлтэй сонгогчид зориулсан том барьцтай үзэг эсвэл цоолтуур зэрэг туслах хэрэглэгдэхүүн байна уу?	Тийм	Үгүй
Сонголын бэрхшээлтэй сонгогч			
24.	<p>Сонгуулийн хэсгийн ажилтнууд сонсголгүй сонгогчийг хүндэтгэн чиглүүлж /туслалцаа/ өгч байна уу? Дохионы хэлээр эсвэл харилцах самбар ашиглан бичгээр харилцаж байна уу?</p> <p><i>Харилцахдаа хэрхэн харилцаж байгааг тэмдэглэх:</i></p> <p>.....</p> <p>.....</p>	Тийм	Үгүй
24 а.	Хэл ярианы бэрхшээлтэй сонгогчийн онцлогийг харгалзан харилцах самбар ашиглан харилцаж байна уу?	Тийм	Үгүй

25.	Сул сонсголтой болон сонсголоо алдсан сонгогчтой харилцахдаа хэрхэн харилцаж байна вэ?	Тийм	Үгүй
26.	Санал авах байранд саналаа хэрхэн өгөх үйл явцыг харуулсан зурагт үзүүлэн зааварчилгаа болон хадмал, дохионы хэлтэй видео үзүүлж байна уу?	Тийм	Үгүй
Оюуны бэрхшээлтэй сонгогч			
27.	Оюуны бэрхшээлтэй сонгогчид санал өгөх зааврыг ойлгомжтой өгч байна уу?	Тийм	Үгүй
28.	Оюуны бэрхшээлтэй сонгогч хэрхэн санал өгөх нь ойлгомжгүй байна уу?	Тийм	Үгүй
29.	Оюуны бэрхшээлтэй сонгогч санал өгөхөд тайван, тусдаа хүлээх орчныг бүрдүүлсэн байна уу?	Тийм	Үгүй
30.	Оюуны бэрхшээлтэй сонгогчийн санал өгөх эрхийг хязгаарласан тохиолдол гарсан уу? <i>Тэмдэглэгээ:</i>	Тийм	Үгүй
Бусад			
31.	Бичиг үсгийн боловсрол багатай сонгогчид зориулан санал тэмдэглэх зурган зааварчилгаа болон нэр дэвшигчдийн зурагтай саналын хуудас хэвлэсэн байна уу? <i>Тэмдэглэгээ:</i>	Тийм	Үгүй
32.	Санал өгөх үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй сонгогчтой холбоотой бусад асуудлыг энд тэмдэглэнэ үү.		



Хавсралт 3. Эрх зүйн баримт бичиг, зүйл заалтын жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль

14.2-р зүйл. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

2. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030

Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчмын хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (2020 он)

9.1-р зүйл. Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлуудыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:

9.1.4-р зүйл. Саналын нууцлалыг хангах зориулалт бүхий хавтас, брайль хавтас, дугтуй, саналын хуудасны уут, лац болон тэдгээрийг худалдан авах, тээвэрлэх болон энэ хуулийн 16.6.5-д заасан олон улсын буухиа шуудангийн зардал.

41.27-р зүйл. Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байна.

56.3-р зүйл. Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрт байна.

56.4-р зүйл. Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.

56.5-р зүйл. Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.

62.9-р зүйл. Эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл болон боловсролын түвшнээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар саналаа өгч болно.

62.16-р зүйл. Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 62.5-д заасан зааврыг батлахдаа хөгжлийн бэрхшээлтэй сонгогч саналаа өгснийг илэрхийлэх тэмдэглэгээг тусгасан байна.

63.13-р зүйл. Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй, хараат бус төрийн бус байгууллага нь сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх эрхтэй.

4. Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016 он)

30 дугаар зүйл. Улс төрийн үйл ажиллагаанд оролцох

30.1-р зүйл. Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

30.2-р зүйл. Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байна.

30.3-р зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдох, төрийн аливаа албанд томилогдон ажиллахад нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих үүрэгтэй.

30.4-р зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгана.

11 дүгээр зүйл. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх

11.2.4-р зүйл. Цахим хуудас болон телевизийн мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн болон өргөн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, текст унших боломжтой байдлаар нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх;

11.2.5-р зүйл. Төрийн болон нийтийн үйлчилгээний байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дохионы хэлний хэлмэрч, орчуулагч, бичигч, уншигч, хөтөчийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх.

5. Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөлийн 2009 оны 51 дүгээр тогтоол

А) Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага /MNS 6055:2009/

Б) Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар /MNS 6056:2009/ стандартууд (Хавсралт 6)



Хавсралт 4. Мэдээллийн хүртээмжийн мониторингийн тэмдэглэгээ хийх хуудас

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ХУГАЦААНД ТЕЛЕВИЗИЙН СУВГААР СОНГОГЧИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ХӨТӨЛБӨР МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖИЙН МОНИТОРИНГ	
Ажиглагчийн овог нэр	
Ажиглагчийн нас, хүйс	
Ажиглагчийн хөгжлийн бэрхшээлийн төрөл эсвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн төлөө ажилладаг талбар	
Мониторинг хийсэн огноо	
Мониторинг хийсэн телевизийн суваг	МҮОНТ, ТВ9, Ийгл

Огноо Цаг	Нэвтрүүлэг мэдээллийг бэлтгэсэн байгууллага	Нэвтрүүлэг, мэдээллийн нэр	Дохионы хэлний орчуулгатай эсэх	Дохионы хэлний хэлмэрчийг зохистой үзүүлсэн эсэх	Хадмалтай эсэх	Хадмалыг зохистой харуулсан эсэх	Баримтжуулсан зураг

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ХУГАЦААНД ТЕЛЕВИЗИЙН СУВГААР УЛС ТӨРИЙН НАМ, НЭР ДЭВШИГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖИЙН МОНИТОРИНГ	
Ажиглагчийн овог нэр	
Ажиглагчийн нас, хүйс	
Ажиглагчийн хөгжлийн бэрхшээлийн төрөл эсвэл	

хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн төлөө ажилладаг талбар	
Мониторинг хийсэн огноо	
Мониторинг хийсэн телевизийн суваг	МҮОНТ, ТВ9, Ийгл

Огноо Цаг	Нэвтрүүлэг мэдээллийг бэлтгэсэн улс төрийн намын нэр	Нэвтрүүлэг, мэдээллийн нэр	Дохионы хэлний орчуулгатай эсэх	Дохионы хэлний хэлмэрчийг зохистой үзүүлсэн эсэх	Хадмалтай эсэх	Хадмалыг зохистой харуулсан эсэх	Баримтжуулсан зураг

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ХУГАЦААНД УЛС ТӨРИЙН НАМ, НЭР ДЭВШИГЧИЙН АЛБАН ЁСНЫ ЦАХИМ ХУУДАС, ФЭЙСБҮҮК ХУУДАС ДАХЬ ВИДЕО МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖИЙН МОНИТОРИНГ	
Ажиглагчийн овог нэр	
Ажиглагчийн нас, хүйс	
Ажиглагчийн хөгжлийн бэрхшээлийн төрөл эсвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн төлөө ажилладаг талбар	
Мониторинг хийсэн огноо	
Мониторинг хийсэн цахим хуудас, Фэйсбүүк хуудас	МАН, ХҮН, АН

Нийтэлсэн огноо, цаг	Видео мэдээллийн нэр	Дохионы хэлний орчуулгатай эсэх	Дохионы хэлний хэлмэрчийг зохистой үзүүлсэн эсэх	Хадмал орчуулгатай эсэх	Хадмал орчуулгыг зохистой харуулсан эсэх	Баримтжуулсан зураг

**СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ХУГАЦААНД УЛС ТӨРИЙН НАМ, НЭР
ДЭВШИГЧИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ХЭВЛЭМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МЭДЭЭЛЛИЙН
ХҮРТЭЭМЖИЙН МОНИТОРИНГ**

Ажиглагчийн овог нэр	
Ажиглагчийн нас, хүйс	
Ажиглагчийн хөгжлийн бэрхшээлийн төрөл эсвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн төлөө ажилладаг талбар	
Мониторинг хийсэн огноо	
Мониторинг хийсэн байршил	



Хэвлэмэл бүтээгдэхүүн хүлээн авсан огноо	Хэвлэлийн нэр, товч агуулга	Бүтээгдэхүүний хэвлэлийн хэмжээ, хуудсын тоо өнгө, төрөл	Брайл үсгээр хэвлэж хүргэсэн эсэх	Сул хараагай хүнд зориулж том үсгээр хэвлэсэн эсэх	Audio, DAISY форматад хөрвүүлж хүргэсэн эсэх	Баримтжуулсан зураг

**СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ МЭДЭЭЛЛИЙГ ТЕЛЕВИЗЭЭР ХҮРГЭХ
ХҮРТЭЭМЖИЙН МОНИТОРИНГ**

Ажиглагчийн овог нэр	
Ажиглагчийн нас, хүйс	
Ажиглагчийн хөгжлийн бэрхшээлийн төрөл эсвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн төлөө ажилладаг талбар	
Мониторинг хийсэн огноо	6 сарын 9, 10
Мониторинг хийсэн телевизийн суваг	МУОНТ, ТВ9, Ийгл

Огноо Цаг	Нэвтрүүлэг, мэдээллийг бэлтгэсэн байгууллага	Нэвтрүүлэг, мэдээллийн нэр	Дохионы хэлний орчуулгатай эсэх	Дохионы хэлний хэлмэрчийг зохистой үзүүлсэн эсэх	Хадмалтай эсэх	Хадмалыг зохистой харуулсан эсэх	Баримтжуулсан зураг

Хавсралт 5. Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн сонгуульд оролцсон туршлагын талаар асуумж

Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчоос авах асуумж			
Ажиглагчийн овог нэр:			
Ажиглагчийн нас, хүйс:			
Ажиглагчийн хөгжлийн бэрхшээл, ажилладаг салбар:			
Огноо:			
Санал асуулгад оролцогчийн нас хүйс:			
Харьяа аймаг, дүүрэг:			
Сонгууль:		МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль 2021	
Сонгуулийн хэсгийн нэр:			
Санал авах байрны дугаар:			
Асуулгад оролцогчийн хөгжлийн бэрхшээл:			
Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байдал			
1.	Санал авах байранд таны хөгжлийн бэрхшээлийг ажиглаж, тусламж хэрэгтэй байгаа эсхийг сонгуулийн хэсгийн ажилтан асуусан уу?	Тийм	Үгүй
1а.	Санал авах байранд та өөрөө сонгуулийн хэсгийн ажилтнаас туслалцаа хүссэн үү?	Тийм	Үгүй
2.	Санал өгөхөд танд ялгаварлагдаж гадуурхагдсан юм шиг санагдсан уу?	Тийм	Үгүй
3.	Танд туслах үйлчилгээ үзүүлэх явцдаа таны саналаа бие дааж өгөх боломжийн хангасан уу?	Тийм	Үгүй
4.	Саналын хуудас танд ойлгомжтой байсан уу?	Тийм	Үгүй
5.	Саналаа тэмдэглэх хангалттай цаг хугацаа танд олгосон уу?	Тийм	Үгүй
6.	Нэр дэвшигчдийн талаар та хангалттай мэдээлэл авсан уу?	Тийм	Үгүй
7.	Саналын хуудас бөглөхөд хялбар байсан уу?	Тийм	Үгүй
8.	Саналын бүхээгийг ашиглахад танд саадгүй байсан уу?	Тийм	Үгүй
9.	Санал тоолох төхөөрөмжид саналын хуудсаа хийхэд саадгүй байсан уу?	Тийм	Үгүй

10.	Саналын хуудас дээр нэр дэвшигчийн зураг тод байсан уу?	Тийм	Үгүй
11.	Саналаа өгөхдөө та зураг, бичиг эсвэл дарааллыг харж тэмдэглэсэн үү?	Тийм	Үгүй
12.	Санал өгөх үйл явц болон санал авах байрыг ямар байна гэж та дүгнэх вэ?		
13.	Сонгуулийн хэсгээс танд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид сонгуулийг хэрхэн хүртээмжтэй зохион байгуулж буй талаар мэдээлэл өгсөн үү? Хэрвээ өгсөн бол танд ямар мэдээлэл өгсөн бэ?	Тийм	Үгүй
14.	Сонгуулийн талаар та ямар мэдээлэл авсан бэ? Мэдээллийг яаж авсан бэ?		
15.	Хэвлэл мэдээллээр танд мэдээлэл хангалттай хүргэсэн үү?	Тийм	Үгүй
16.	Улс төрийн намууд танд хангалттай мэдээлэл хүргэсэн үү?	Тийм	Үгүй
17.	Сонгогчийн нэрийн жагсаалтад нэр нь ороогүй таны мэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүн байсан уу? Тийм бол яагаад ороогүй юм бол? Тайлбарлаж өгнө үү.	Тийм	Үгүй
18.	Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид яаж илүү хүртээмжтэй сонгууль зохион байгуулах хэрэгтэй гэж бодож байна вэ?		

Санал авах байрны орчны хүртээмжийн сайн эсвэл муу байсан тухай тэмдэглэл

--

Санал авах өдрийн үйл явцын сайн эсвэл муу байсан тухай тэмдэглэл

--

Хавсралт 6. Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөлийн 2009 оны 51 дүгээр тогтоол

Дараах стандарт нь иргэний барилга (орон сууц, төрийн болон хувийн хэвшлийн албан, үйлчилгээний барилга гэх мэт)-д мөрдөгддөг.

- **Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага /MNS 6055:2009/,**
 - **Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар /MNS 6056:2009/ стандартууд**
- Барилга, өрөө тасалгааны гол хаалга нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглах боломжтой 85 см-ээс багагүй өргөнтэй, орон зай нь уужим цэлгэр байна.
 - Хаалганы бариул: - Шалнаас дээш 90 см-100 см, - Урд ирмэгээс хойш 20 см
 - Хаалганы хэмжээ: - Босгоны өндөр $\leq 2,5$ см, эсвэл босгогүй байх - Хаалганы өргөн ≥ 85 см
 - Анхааруулах зурвасыг шалнаас дээш 1,6 м-ийн өндөрт 15 см-ийн өргөнтэйгээр тод өнгөөр тэмдэглэнэ.
 - Налуу шатны стандартаар өндрийн хэмжээ хамгийн ихдээ 0,12 м байх тохиолдолд уртын хэмжээ 1 м байхаар тооцно.
 - Налуу замын эхлэл, төгсгөлд тэгш талбай байгуулах ба түүний урт нь налуу зам (пандус)-ын өргөнөөс багагүй байна. Налуу замын өргөн 1,2 м-ээс багагүй байна. Урт хийгдэх тохиолдолд замын чиглэлийг өөрчлөн дугуйрсан байдлаар хийж, налуу замын дугуйрах хэсэг тэргэнцэр эргэх боломжтой буюу 1.5 м-ээс багагүй байна
 - Налуу замын 2 хажуу талаар 90 см-ээс багагүй өндөрт бариул бүхий хашлагыг хийнэ. Бариулыг 2 эгнээгээр байрлуулж, тэдгээрийн өндөр нь 70 см ба 90 см байна. Налуу замын бариулын хийц шатны бариулын хийцтэй адилхан байна. Сургуулийн өмнөх насныханд зориулж 50 см өндөрт бариул төлөвлөж болно.
 - Харааны бэрхшээлтэй хүнд зориулсан зам, ханын бариул Барилга байгууламжийн дотор болон гадна талд харааны бэрхшээлтэй хүнд зориулсан брайль замыг хийх шаардлатай. Байгууллагын дотор талд хийх тохиолдолд байгууллагын үүднээс мэдээлэл лавлагааны хэсэг хүртэл болон өрөө тасалгааны бүх чиглэлд брайль зам хийж болно. Эсвэл ханын дагуу бариул хийнэ. Ханын бариулыг хийх тохиолдолд 75 см-ийн өндөрт 8 см-ээс илүүгүй өргөнтэй бариулыг хана дагуулж хийнэ.
 - Ариун цэврийн өрөөнд тэргэнцэртэй хүнд зориулсан нэгээс доошгүй тасалгааг төлөвлөх ба түүний хамгийн бага хэмжээ нь 1.65м x 1.8м байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн тэргэнцрээс суултуур дээр шилжин суух боломжийг хангахын тулд ариун цэврийн өрөө (кабин)-д байгаа суултуурын хажуу хэсэгт тэргэнцэр байршуулах чөлөөт орон зай (талбай)-г гаргана. Нийтийн бие засах өрөөг тулгуур, таяг болон бусад тоног, хэрэгсэл ашигладаг хүнд зориулж, хажуугийн хана, дагуулсан бариул, хувцасны өлгүүр, бусад хамрагдах тоноглолын хамт тохижуулна.
 - Нийтийн бие засах өрөөний гар угаах хэсэгт нэгээс цөөнгүй тосгуурыг шалнаас 80 см-ээс ихгүй өндөрт, хажуугийн хананаас 20 см-ээс багагүй зайд толь, гар хатаах төхөөрөмж болон гарын алчуур хатаах өлгүүрийг шалнаас

90 см-ээс ихгүй өндөрт байршуулна. Угаалтуур нь тэргэнцэртэй хүнд зориулагдсан өндөр нь 80 см-ээс ихгүй байна.

- Лангуу (өөрөөр хэлвэл саналын бүхээг) Үйлчилгээний тавцан /лангуу/-г одой хүн болон тэргэнцэртэй хүний орон зайг тооцоолж, хангалттай хэмжээнд байрлуулна. Тэргэнцэртэй хүнд зориулж лангууны дэргэд тусгай талбай гарган шалны түвшинг хангалттай өндөрсгөнө. Тавцангийн өндөр нь 70 см, өргөн нь 1 м, тавцангийн тэргэнцэр орох зай нь 50 см байна.
- Замын налуу хавтан Налуу хавтан нь тэргэнцэртэй зорчигч явган хүний замаас гудамжинд шилжих боломжийг олгодог хамгийн чухал хэрэглүүр юм. Налуу хавтанг уулзвараас гадна гудамжин дахь машины зогсоол, ачиж буулгах хэсэг, автобусны буудал, хорооллын дундах гарц зэрэгт хийдэг. Автомашины гарцтай хэсэгт явган хүний замыг 2%-ийн налуутай хийнэ.
- Харааны бэрхшээлтэй хүнд зориулсан зам Харааны бэрхшээлтэй хүн нь явган хүний замаар зорчихдоо автомашины замын чимээ, замын налуу хашлага, барилга байшин, мөн өөрийн явсан зам болон хүрэх газар хоорондын зайгаар баримжаалан чиглэлээ олж явдаг
- Автомашины зогсоол Нийт авто зогсоолын 4%-д нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан авто зогсоолыг төлөвлөж, тэмдэг тэмдэглэгээг байршуулна. Зогсоолыг төлөвлөхдөө 3,5м х 5м -ийн харьцаатай хийж, цэнхэр өнгөөр ялгаж өгөх ба зогсоолын голд цагаан өнгөөр тэргэнцрийн дүрсийг байршуулна.